



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

2008 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Даланзадгад

Дугаар 28

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь: Нэг . Орон нутгийн өмчийн үл хөдлөх ба хөдлөх хөрөнгө, илүүдэлтэй ажлын байрны талбайг түрээслүүлэх журмыг нэгдүгээр хавсралтаар, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж , байгууллагын эзэмшилд байгаа өрөө тасалгааны нэг ам метр талбайн түрээсийн төлбөрийн доод үнийг хоёрдугаар хавсралтаар, орон нутгийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай. Хоёр. Дээрх журам батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 3 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт, 2002 оны 21 дүгээр тогтоолын нэг дэх заалт, аймгийн ИТХ-ын 2002 оны 5/3 тогтоолын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

С.ЦЭРЭНБАЯР